

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ АРВАНЕСДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2017 оны долдугаар сарын 06-ны 10 цаг 50 минутад эхэлж, 11 цаг 50 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д 50 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Орхон, Өмнөговь аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо нөхөх мэргэшлийн шалгалтын дүн	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2017 оны 06 дугаар сарын 19-ны өдрөөс 06 дугаар сарын 22-ны өдрүүдэд Орхон аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 11 иргэнийг “дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 11 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д

бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 3 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 8 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 2 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх

3. Энэхүү тогтоолын 3,4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 10 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Орхон аймаг дахь Салбар зөвлөл /Д.Соёлчхүү-д үүрэг болгох

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамбад даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 17-ны өдрүүдэд Өмнөговь аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн

		<p>жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 14 иргэнийг “дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 3 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 3 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 7 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 2 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх3. Энэхүү тогтоолын 3,4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 9 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн
--	--	---

		<p>Өмнөговь аймаг дахь Салбар зөвлөл /Ө.Баянмөнх/-д үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамбад даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
2	<p>Төрийн албаны зөвлөлийн Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг", "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 118 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн батлах Үүнд:</p> <p>Салбар зөвлөлийн дарга</p> <ul style="list-style-type: none"> - Тагнуулын ерөнхий газрын дарга <p>Гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Тагнуулын ерөнхий газрын дэд дарга - Төрийн албаны төв байгууллагын төлөөлөл - Тамгын газрын дарга - Нэгдүгээр газрын дарга

		<ul style="list-style-type: none">- Хоёрдугаар газрын дарга- Аравдугаар газрын дарга- Дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах чиг үүрэг хариуцсан газрын дарга- Захиргаа, эрх зүйн хэлтсийн дарга- Хүний нөөцийн асуудал хариуцсан хэлтсийн дарга <p>Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга</p> <ul style="list-style-type: none">- Хүнийн нөөцийн асуудал хариуцсан ахлах ажилтан <p>2. Хуульд өөрөөр заагаагүй бол Төрийн албаны зөвлөлийн Тагнуулын газрын дэргэдэх Салбар зөвлөлийг удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, дүгнэлт гаргаж нэр дэвшүүлэх, албан тушаалын зэрэг дэв олгох, албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлага, ёс зүй, төрийн албатай холбогдон гарсан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Баатарзоригт, Тагнуулын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг зохион байгуулж, нэр дэвшүүлэх, төрийн жинхэнэ албаны удирдах болон тусгай албанд анх орох иргэний нөөцийн сан бүрдүүлэх, албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамбад тус тус даалгах</p> <p>3. Төрийн албаны зөвлөлөөс 2017 оныг "Хариуцлага үр дүнгийн жил" болгосонтой холбогдуулан Төрийн албаны тухай</p>
--	--	--

	<p>хууль түүнтэй холбогдон гарсан дүрэм, журмыг хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагааг шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн дарга Б.Хурцад үүрэг болгох</p> <p>4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Хоёр”-ын 12 дахь хэсэг, 2 дугаар хавсралтын “Хоёр”-ын 12 дахь хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргыг өөрчлөн томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 15, “Төрийн албаны зөвлөлийн Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг өөрчлөн томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 16 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
--	--

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА**